

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

Батлан хамгаалах яамны Барилга захиалагчийн алба  
ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** САГ-2019/25/СТА-ТӨҮГ

**Агуулга**

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан.....	4
	2.1. Оршил.....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
	2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл .....	7
	2.8.2 . Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	7
	2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээс шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	8
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
	2.10. Үйл ажиллагааны орлого, зарлагын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
	2.11. Шилэн дансны мэдээлэл .....	8
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	8
	2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
3	Менежментийн захидал.....	10
	3.1 НББ-ийн бодлогын бичиг баримттай холбоотой асуудал.....	10
	3.2 Авлага, өглөгтэй холбоотой асуудал.....	10
	3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: .....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ  
БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН АЛБА  
ТӨААТҮГ-ЫН ДАРГА Э.МӨНХНАРАН  
ТАНАА

2019.03.20 № 06/527  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Батлан хамгаалах яамны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Батлан хамгаалах яамны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Батлан хамгаалах яамны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Батлан хамгаалах яамны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Батлан хамгаалах яамны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын / цаашид Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ гэх/ 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын захирал Э.Мөнхнаран Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 25-наас 03 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Эвиденсе Аудит ХХК-ийн Захирал, Аудитор С.Бадамгарав, аудиторовн туслах Т.Болортуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ 2018 оны санхүүгийн тайланг тодруулгын хамт Эвиденсе Аудит ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 48 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ нь “Инженерийн хийцтэй барилга, байгууламж шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, засварлах зэрэг ажил явуулах нөхцөлийг зохих журмын дагуу бүрдүүлж эхлүүлэх, ажлын явцад чанарын болон технологийн хяналт тавьж гүйцэтгэлийг баталгаажуулах, хуваарилагдсан хөрөнгийг үр ашигтай зарцуулах, материал тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг оновчтой зохион байгуулах, үндсэн фондыг тогтоосон хугацаанд нь ашиглалтанд оруулахад барилга захиалагчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ өөрийн үйл ажиллагаандаа Батлан хамгаалахын сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн А/200 тоот тушаалаар батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн дагуу барилгын иж бүрэн зураг төсөл боловсруулах, үе шатны ажилд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх, барилга байгуулмжийг ашиглалтад оруулах, ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах ажлыг гүйцэтгэгч, ашиглагч, зураг төсөл боловсруулан хуулийн этгээдүүдтэй хамтран хэрэгжүүлэх бодлого чиглэлийн дагуу ажиллах гэж үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлжээ.

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцээгүй байна.

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Unicus” програм хангамж ашигладаг байна.

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, тодруулгатай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын үзүүлэлтийг сонгов.

Санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь уг компани нь төрийн өмчит компани, мөн бусад үзүүлэлтүүдээс хамгийн бага дүнтэй тул сонгосон ба материаллаг байдлын түвшинг тогтоохдоо хэрэглэгчдийн хэрэгцээ, өмнөх жилийн аудитын тайлангаар гарсан алдаа, зөрчлийн дүн, агуулгыг бас харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого нь 348.6 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 3.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь тухайн байгууллага аудитын чиглэлүүдэд үзүүлж болзошгүй эрсдлийн “Дунд” үнэлгээг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

### 2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

#### Асуудал 1: Найдваргүй авлагатай холбоотой

Өмнөх жилүүдэд үүссэн эзэн холбогдогч нь байхгүй болсон найдваргүй авлагын зардлыг тайлант үеийн зардалд хаасан.

#### Шийдэл:

Өмнөх үеийн хуримтландсан үр дүн рүү хааж залруулсан

#### Асуудал 2: Орлогын татварын зардалтай холбоотой

Тайлант жилд орлогын татварын зардал, өглөгийг дутуу тооцоолсон.

#### Шийдэл:

Татварын тооцооллыг хийж залруулсан.

### 2.8.2 . Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	88.3	
	Дүн	2	88.3	



Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

#### **2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээс шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн асуудал гараагүй болно.

#### **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгийн үнэлгээний талаар, урьдчилж гарсан зардлын дансыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

#### **2.10. Үйл ажиллагааны орлого, зарлагын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 564 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилт түвшний орлогыг 301.6 сая төгрөгөөр, зардлыг 267.1 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант жилд үндсэн үйл ажиллагаанаас 340.4 сая төгрөг, хүүгийн болон бусад орлогоос 8.1 сая төгрөг нийт 348.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж зорилтот түвшингийн орлогын төлөвлөгөөгөө 15.57 хувиар буюу 46.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Зарлагын төлөвлөгөө 140.4 хувийн гүйцэтгэлтэй гарч борлуулалтын өртөгт 75.2 сая төгрөг, ерөнхий ба удирдлагын зардалд 223.7 сая төгрөг, бусад зардалд 1.5 сая төгрөг зарцуулсан байна. Тайлант жилд 39.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

#### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг бүрэн оруулсан байна. Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн нэгтгэсэн мэдээллийг, зорилтот түвшний гүйцэтгэлийг, худалдан авалт, хагас жилийн санхүүгийн тайланг тус тус байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

#### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 НББ-ийн бодлогын бичиг баримттай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Тус байгууллагын НБББББ-ийг 2010 онд боловсруулсан боловч байгууллагын үйл ажиллагааны онцлог, чиглэл, нягтлан бодох бүртгэлтэй нийцээгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

НБББББ нь хангалтгүй байснаар СТОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөхөд хүндрэл гарах, СТОУС-ыг дутуу мөрдөх, буруу хэрэглэх, бүртгэлийн үйл ажиллагаа нь ажилтнуудын мэргэжлийн шийдлийн хүрээнд явагдахад сөрөг нөлөөллүүд гарч болно.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

СТОУС болон холбогдох хууль журмын шаардлагад нийцсэн НБББББ-ийг боловсруулан СТОУС-ын шинэчлэлт өөрчлөлтийг тухай бүр нэмэлт өөрчлөлт болгон тусгах нь зүйтэй

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

НБББББ-г шинэчлэн боловсруулж ажиллана. Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ.

#### **3.2 Авлага, өглөгтэй холбоотой асуудал**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

2011 оноос үүссэн Бага Баян Энхийн төлөө амралт сувилалын цогцолбор барьсан гүйцэтгэгч БСИЖМН ХХК-т өгөх барьцааны 88.3 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж

баталгаажуулах, мөн барьцааны өглөгийг тусад нь мөнгөн хөрөнгийн хадгаламжийн данс нээж байршуулах.

### **3.2.2 Эрсдэл:**

Гэрээнд заасан ер төлбөр төлөх чадваргүй болох эрсдэлтэй

### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Мөнгөн хадгаламжийн данс нээж байршуулах, БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМТАЙ тооцоо нийлж баталгаажуулах

### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 сарын 31-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4 Аудит хийсэн санхүүгийн тайлан****4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	286,224,204.57	613,624,054.97
1.1.2	Дансны авлага	87,425,476.05	
1.1.4	Бусад авлага	156,588,397.12	23,777,287.43
1.1.6	Бараа материал	37,381,814.50	40,619,313.50
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	134,526,629.92	67,040,619.92
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>702,146,522.16</b>	<b>745,061,275.82</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	89,976,043.53	56,570,065.37
1.2.2	Биет бус хөрөнгө	1,673,666.82	118,866.86
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>91,649,710.35</b>	<b>56,688,932.23</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>793,796,232.51</b>	<b>801,750,208.05</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	137,228,305.00	305,541,447.10
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	19,513,544.88	7,085,894.93
2.1.1.4	НДШ-ийн өглөг	2,328,744.05	
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	210,734,855.43	90,540,424.69
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>369,805,449.36</b>	<b>403,167,766.72</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>369,805,449.36</b>	<b>516,189,485.37</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	125,043,641.34	125,043,641.34
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	24,496,368.57	24,496,368.57
2.3.9	Хуримтлагдсан ашиг	274,450,773.24	249,042,431.42
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>423,990,783.15</b>	<b>398,582,441.33</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>793,796,232.51</b>	<b>801,750,208.05</b>

**4.2 Аудит хийсэн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлан**

2018 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	529,402,665.33	340,852,629.00
2	Борлуулалтын өртөг	196,836,285.00	75,193,424.00
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>332,566,380.33</b>	<b>265,659,205.00</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого		7,707,990.50
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	274,387,056.28	223,735,084.12
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(35,963.09)	
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(6,445,860.67)	(8,518,400.00)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
<b>17</b>	<b>Бусад ашиг ( алдагдал)</b>	<b>(5,953,655.18)</b>	<b>(1,500,000.00)</b>
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>45,743,845.11</b>	<b>39,613,711.38</b>
19	Орлогын татварын зардал	6,217,551.32	4,963,211.14
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>39,526,293.79</b>	<b>34,650,500.24</b>
<b>21</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>39,526,293.79</b>	<b>34,650,500.24</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>		
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

**4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	<b>125,043,641.34</b>	<b>24,496,368.57</b>	<b>274,450,773.24</b>	<b>423,990,783.15</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
3	Залруулсан үлдэгдэл				
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)			34,650,500.24	<b>34,650,500.24</b>
5	Бусад дэлгэрэнгүй орлого				
6	Өмчид гарсан өөрчлөлт			(60,058,842.06)	<b>(60,058,842.06)</b>
7	Зарласан ногдол ашиг				
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
9	2018 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	<b>125,043,641.34</b>	<b>24,496,368.57</b>	<b>249,042,431.42</b>	<b>398,582,441.33</b>

## 4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,036,668,883.03</b>	<b>955,474,047.68</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	553,430,732.64	264,606,601.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	7,697,000.00	298,836,475.58
1.1.6	Бусад мөнгөн орлого	475,541,150.39	392,030,971.10
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>911,985,058.16</b>	<b>635,782,187.78</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	90,155,983.09	95,658,259.45
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	9,773,476.89	20,383,886.93
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	35,019,112.00	91,003,954.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	181,487,233.44	91,469,671.07
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	17,762,535.00	16,807,110.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	7,585,500.09	23,647,968.19
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	570,201,217.65	296,811,338.14
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>124,683,824.87</b>	<b>319,691,859.90</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>10,442,049.80</b>	<b>7,707,990.50</b>
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	10,442,049.80	7,707,990.50
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>10,442,049.80</b>	<b>7,707,990.50</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>49,010.29</b>	
3.1.4	Бусад	49,010.29	
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>84,973.38</b>	
3.2.5	Бусад	84,973.38	
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-35,963.09</b>	
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>		
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>135,089,911.58</b>	<b>327,399,850.40</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>151,134,492.99</b>	<b>286,224,204.57</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>286,224,204.57</b>	<b>613,624,054.97</b>



**4.5 Аудит хийсэн 2018 оны зорилтот түвшин, гүйцэтгэл**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

№	Зардлын төрөл, ангилал	2018 оны		Зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүнгээр	Хувиар
<b>A</b>	<b>Орлого</b>				
1	ТХ орлого	294,568,950	340,422,013	45,853,063	115.57%
2	Хүүгийн орлого	7,000,000	7,707,991	707,991	110.11%
3	Бусад орлого		430,616	430,616	
	<b>Орлогын дүн</b>	<b>301,568,950</b>	<b>348,560,620</b>	<b>46,991,670</b>	<b>115.58%</b>
<b>Б</b>	<b>Зардал</b>			-	
1	Цалингийн зардал	101,839,468	115,949,253	14,109,785	113.85%
2	ЭМ, НДШ	7,833,531	4,749,555	(3,083,976)	60.63%
3	Элэгдлийн зардал	25,711,360	26,442,378	731,018	102.84%
4	Ашиглалтын зардал	8,541,632	8,986,157	444,525	105.20%
5	Засвар үйлчилгээний зардал	47,209,000	5,504,720	(41,704,280)	11.66%
6	Бичиг хэргийн зардал	3,865,200	2,446,300	(1,418,900)	63.29%
7	Албан томилолтын зардал	6,900,000	6,950,240	50,240	100.73%
8	Нийгэм ахуйн хөнгөлөлт	1,080,000	500,000	(580,000)	46.30%
9	Материалын зардал	1,452,000	2,638,717	1,186,717	181.73%
10	Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлийн зардал	230,250	2,156,000	1,925,750	936.37%
11	Шуудан холбооны зардал	3,468,000	4,347,182	879,182	125.35%
12	Хэвлэл, мэдээллийн зардал	512,000	397,100	(114,900)	77.56%
13	Сургалтын зардал	500,000	615,000	115,000	123.00%
14	Автомашин шатахуун зарцуулалтын норм	14,359,652	16,454,110	2,094,458	114.59%
15	Шатах тослох материалын зардал	1,238,000	401,000	(837,000)	32.39%
16	Татвар хураамж /Тээврийн хэрэгсэл/	480,000	-	(480,000)	0.00%
17	Сэлбэгийн зардал /Тээврийн хэрэгсэл/	1,600,000	1,957,200	357,200	122.33%
18	Гүйцэтгэлтэй холбоотой зардал	19,250,000	75,193,424	55,943,424	390.62%
19	Бусад зардал	20,980,000	99,385,645	78,405,645	473.72%
	<b>Нийт зардал</b>	<b>267,050,093</b>	<b>375,073,982</b>	<b>108,023,889</b>	<b>140.45%</b>

## 5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Огноо:</b>	2019.03.05	<b>Аудитын нэр:</b>	Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, тодруулагад хийсэн аудитын тайлан	<b>Аудитын код:</b>
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН АЛБА ТӨААТҮГ			САГ-2019/25/СТА-ТӨҮГ
				Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Найдваргүй авлагатай холбоотой-Өмнөх жилүүдэд үүссэн эзэн холбогдогч нь байхгүй болсон найдваргүй авлагын зардлыг тайлант үеийн зардалд хаасан.	65.3	Залруулсан	Нягтлан бодогч	А.Дорж
2	Орлогын татварын зардалтай холбоотой- Тайлант жилд орлогын татварын зардал, өглөг дутуу тооцоолсон.	4.2	Залруулсан	Нягтлан бодогч	А.Дорж
3	Тус байгууллагын НБББББ-ийг 2010 онд боловсруулсан боловч байгууллагын үйл ажиллагааны онцлог, чиглэл, нягтлан бодох бүртгэлтэй нийцээгүй байна.		Зөвлөмж өгсөн	Нягтлан бодогч	А.Дорж
4	2011 оноос үүссэн Бага Баян Энхийн төлөө амралт сувилалын цогцолбор барьсан гүйцэтгэгч БСИЖМН ХХК-т өгөх барьцааны өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах, мөн барьцааны өглөгийг тусад нь мөнгөн хөрөнгийн хадгаламжийн данс нээж байршуулах.	88.3	Зөвлөмж өгсөн	Нягтлан бодогч	А.Дорж
	<b>Дүн</b>	<b>157.8</b>			